



СОЁМБОМ ЭДЭЭ


МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ

№107 /107/ 2021.08.06

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛ, ЯПОНЫ ЦЭРГИЙН ЭМНЭЛГИЙН ЭМЧ НАР ЦАХИМ СУРГАЛТАД ОРОЛЦОВ



Монгол Улсын Батлан хамгаалах яам, Япон Улсын Батлан хамгаалах яам хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжиж байгаа.

Тус хөтөлбөрийн хүрээнд өчигдөр хоёр талын цэргийн эмнэлгийн хамтарсан семинар цахим хэлбэрээр боллоо. Цахим сургалтад Монгол Улсын талаас БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Япон Улсын талаас Энэтхэг номхон далайн Батлан хамгаалах хамтын ажиллагааны дарга, Мацүзава

Томоко удирдан явуулсан ба ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсийн дарга, хурандаа Т.Сүхбаатар, Цэргийн төв эмнэлгийн дарга, Ерөнхий эмч, дэд хурандаа Б.Энх-Од, Цэргийн төв эмнэлгийн Эмнэл зүй эрхэлсэн орлогч дарга, хурандаа Р.Баянмөнх болон бусад албан тушаалтан оролцсон бол Япон Улсын талаас Эмнэлгийн төлөвлөлтийн дарга, хурандаа Ёшинага Ёоскэ, Судалгаа шинжилгээний ахлах офицер, хурандаа Сато Ацүши болон бусад албаны хүмүүс оролцлоо.

Хамтарсан семинар нээж БХЯ-ны Гадаад хамтын

ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ нээж хэлсэн үгэндээ "Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбар хэзээнээс сайхан харилцаатайн дээр цаг үргэлж харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлж байдаг баяртай байна. Энэ удаагийн сургалт нь үүнийг батлан харуулж байгаа бөгөөд цаг үеэ олсон чухал сургалт болж байгааг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. Сургалтад оролцож байгаа та бүхэн өөрсдийн мэдлэг, мэдээллээ энэхүү сургалтаас улам баталгаажуулахын дээр цаашид улс орны эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх олон санаатай болно

гэдэгт итгэлтэй байна. Ингээд та бүхний сургалтад амжилт хүсье" гэв.

Японы өөрийгөө хамгаалах хүчний цэргийн эмнэлэг болон цэргийн эмнэлгийн сургуулийн танилцуулгыг хийж, "Ковид-19" цар тахлын үеэр Японы цэргийн эмнэлэгт хийгдсэн тохиолдлын судалгаа, туршлага сургамжийн талаар илтгэл хэлэлцүүлээ. Цаашид Япон улсын цэргийн эмнэлгийн гамшгийн үеийн анагаах ухааны туршлагыг Монгол Улсын "Цэргийн төв эмнэлэг"-т нутагшуулах хамтарсан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм.

ЦДБЭЧ-ЫН УДИРДЛАГУУДЫН ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар болон БХЯ-ны бусад газар, хэлтсийн дарга нар 8, 9 дүгээр саруудад

хуваарийн дагуу Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын удирдлагатай хийх уулзалтыг зохион байгуулж байна. Тус уулзалтаар тухайн байгууллагын ажлын явц, байгууллагын үйл ажиллагааны талаар илтгэл тайланг сонсож,

тулгамдаж буй асуудал, шийдвэрлүүлэх саналын талаар харилцан ярилцаж, цаашид хэрэгжүүлэх асуудлаар үүрэг чиглэл өгч байгаа юм. Өчигдөр хуваарийн дагуу Батлан хамгаалах яамны Стратеги, бодлоготөлөвлөлтийн

газрын дарга, хурандаа С.Ганбямба, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Төрийн захиргаа удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, хурандаа О.Нямчулуун нар Батлан хамгаалахын сайдын баталсан "ЦДБЭЧ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө", Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "ЦДБЭЧ-ын 2020-2021 оны Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө"-нүүдийн хэрэгжилт, өвөл сургуулийн бэлтгэл ажлын явц, байгууллагын үйл ажиллагааны талаар илтгэл тайланг сонсож, чуулгаас тулгамдаж буй асуудал, шийдвэрлүүлэх саналын талаар харилцан ярилцаж, цаашид хэрэгжүүлэх асуудлаар үүрэг чиглэл өглөө.

Энэхүү арга хэмжээнд ЦДБЭЧ-ын дарга, хурандаа Г.Золзаяа, Захиргаа үзвэр үйлчилгээний хэлтсийн дарга, дэд хурандаа А.Дондов, Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч Л.Энхзаяа нар оролцлоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	☁️ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	☁️ 20

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.851.0
EUR 🇪🇺	3.38.0	3.395.0
CNY 🇨🇳	441.5	442.5
RUB 🇷🇺	38.40	39.60
JPY 🇯🇵	25.85	26.40
KRW 🇰🇷	2.43	2.53

ЗУРХАЙ

2021.08.06 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 28/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх:

05:35-20:21

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал:

Төмөр

Өдрийн наран 5 цаг 35 минутад мандан, 20 цаг 21 минутад жаргана. Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал худалдан авах, хануур, төөнүүр хийлгэх, хийморийн дарцаг хатгахад сайн. Эрдэнийг гадагш өгөх, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одоосдо урагш мөрөө гаргавал зохистой. Хүүхдийн сэтгэл үргээлгэх буюу үс засуулахад тохиромжгүй бөгөөд нүд бүрэлзэн улцайна хэмээжээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
168.851 +1776	1502.375 +2047	836 +3

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ	ЭДГЭРСЭН
4197 +76	204 +17	3914 +20

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 201,632,042
Эдгэрсэн
Нийт: 181,414,044
Нас барсан
Нийт: 4,279,299

ДЕЛЬТА ХУВИЛБАР
АНХЛААРХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

ЦАГ ҮЕ

МОНГОЛД ВАКЦИНЫ ГУРАВДУГААР ТУНГ ХИЙЖ ЭХЛЭХ БОЛООГҮЙ



Вакцины гуравдугаар тунг хийх эсэх нь иргэдийн сонирхлыг ихэд татаж байна. Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нэг сая 987 мянга 603 иргэн буюу нийт хүн амын 61.1 хувь нь дархлаажуулалтын хоёр тунд хамрагдаад буй. Эмч мэргэжилтнүүдийн хэлж байгаагаар бүрэн тунд хамрагдсан ч халдвар авах эрсдэл өндөр байгаа учир гуравдугаар тунг хийж магадгүй гэж мэдээлсэн. Тэгвэл энэ сард Covid-19 эсрэг вакцины гурав дахь тунг хийх эсэх талаар мэргэжилтнүүдээс тодрууллаа.

**ДЭМБ БОЛОН
ҮЙЛДВЭРЛЭГЧ КОМПАНИУД
ДЭМЖЭЭГҮЙ БАЙНА**

**ХӨСҮТ-ийн захирал
Л.Батгөр:**

“Гурав дахь тунгийн асуудлыг дэлхий нийтээр гэхээс илүүтэй ганц хоёрхон улс орон санал хүргүүлээд байгаа. Тухайлбал, Израиль улс өнгөрсөн долоо хоногоос 60-аас дээш насны иргэдээ нэмэлт тунд хамруулж эхэлсэн. Харин Герман, Их Британи зэрэг орон санал хүргүүлсэн. Монгол Улсын хувьд нийт хүн амын 60 орчим хувь л вакцины хоёр тунг хийлгэсэн байна. Тиймээс энэ сард багтаж гуравдугаар тунг нэмэлтээр хийж эхлэхгүй. Ямартаа ч судалгааны ажлуудыг шат дараатайгаар хийж байна. Одоогийн байдлаар ДЭМБ болон вакцин үйлдвэрлэгч компаниудын зүгээс албан ёсоор зарласан зүйл байхгүй. Хүмүүс вакцин хийлгэх юм бол аюулгүй, дархлаа тогтоно гэж ойлгодог.

Гэхдээ халдвар хамгаалалтын дэглэмийг сахихгүй бол хэн ч халдвараар өвчилж болохыг батлагдсан тохиолдлууд харуулж байна. Гуравдугаар тунг хийлгэсэн ч халдвар авахгүй гэсэн баталгаа байхгүй. Тиймээс тархалтын явц, нөхцөл байдлыг харгалзаж, хүн амын дийлэнх хувь нь хоёрдугаар тундаа хамрагдсаны дараагаар энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэх байх. Түүнээс олон улсад зөвшөөрсөн зүйл байхгүй байхад Монгол Улс судалгаан дээр тулгуурлаад дур мэдэн нэмэлт тун хийнэ гэж болохгүй шүү дээ. Судалгааны ажил ч ганцхан сарын дотор хийгдэнэ гэж байхгүй. Тэгэхлээр энэ сард нэмэлт тун хийхгүй гэж бодож байна.

**ГУРАВДУГААР ТУНГ
ЭНЭ САРД ХИЙХГҮЙ**

**ЭМЯ-ны Нийтийн
эрүүл мэндийн бодлогын
хэрэгжүүлэлтийг
зохицуулах газрын дарга
Л.Энхсайхан:**

“ДЭМБ-ын хийсэн судалгаагаар вакцин халдвараас 90-95 хувь хамгаалдаг болох нь батлагдсан. Хүний биед хамгаалах буюу дархлааны эс 1-2 тунг хийлгэснээр тогтдог. Одоогоор Монгол Улсад гуравдугаар тунг хийнэ гэсэн зөвшөөрөл, ямар нэгэн захирамж гараагүй байна. Бид нэмэлт тунг хийх боломж, нөхцөл юу байгааг судалж байна. “АстраЗенека” вакцины хоёр тунг хийлгэсэн иргэн дараагийн удаа аль үйлдвэрийн вакцин хийлгэх нь зүйтэй болон гурав дахь

тунг хэрэв хийхээр бол иргэд өөрсдийн сонголтоор вакцина сонгох боломжтойг судлах ажил үргэлжилж байна. Зарим улсад гуравдугаар тунг өөрийн хүсэлтээр хийлгэж эхлээд байгаа. Халдварын тархалт, нийтийн дархлаа зэргийг харгалзаж зорилтот бүлгийнхэнд гол төлөв нэмэлт тунг хийж байна. Монголд ч мөн ялгаагүй хийж эхлэх бол 60-аас дээш насныханд хийж магадгүй. Наймдугаар сард гуравдугаар тунг хийж эхлүүлэх ажил хугацааны хувьд хойшлоод байгаа.

Мөн УОК-ын эрдэмтдийн зөвлөлөөс гуравдугаар тунд ач холбогдол өгч байгаа асуухад хүн амын дунд тархаж байгаа халдварын явцыг харвал иргэдийн дархлаажуулалтын идэвх орон нутагт бага байгаатай холбоотой харагдаж байна. Дэлхийн улс орнууд цар тахлын эсрэг гуравдугаар тунг хийж эхэлсэн учраас эрдэмтдийн зөвлөлөөс судалгааны ажлуудыг хийж байгаа. Эхний ээлжинд нэмэлт тунгийн ач холбогдол, үр дүнг ажиглаж, түүний дараагаар хэдээс хэдэн насны хүмүүсийг аль үйлдвэрийн вакцинаар дархлаажуулах эсэх нь тодорхой болно. Эрүүл мэндийн яам болон ХӨСҮТ, эрдэмтдийн зөвлөлөөс харж байгаагаар дэлхийн зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагууд зөвшөөрөл Монгол Улс сүргийн дархлаа үүсгэхийн тулд гуравдугаар тунг хийж эхлэх нь тодорхой. Харин цаг хугацааны хувьд хэзээ гэдэг нь одоогоор тодорхойгүй байна.

ФАЙЗЕР ВАКЦИНЫ 155,610 ТУНГ ӨНӨӨДӨР ХҮЛЭЭН АВНА

Файзер вакцины найм дахь ээлжийн 155,610 тунг өнөөдөр хүлээн авлаа. Монгол Улсын Засгийн газар ба Pfizer Inc (Pfizer/Bio-ntech) компанийн хооронд байгуулсан гэрээний хүрээнд нийлүүлэх 2,5 сая Файзер вакцины 705,510 тунг хүлээн авсан бөгөөд үлдсэн хэсэг нь хуваарийн дагуу ирнэ.

НҮБ-ын Хүүхдийн Сан болон Япон Улсын ЭСЯ хооронд байгуулсан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” төслийн гэрээний дагуу Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар 2,35 сая тун вакцины худалдан авалтыг санхүүжүүлж байна.



ДЭЛХИЙН ХАМГИЙН СТРЕССТЭЙ АЖЛЫН БАЙРУУДЫН ЖАГСААЛТЫГ ГАРГАЖЭЭ

Дэлхий дээрх бүхий л ажил өөрийн гэсэн стресстэй. Гэхдээ зарим ажил нь илүү стресстэй байдаг гэнэ. Ингээд мэргэжил сонголтын CareerAddict сайтаас дэлхийн хамгийн стресстэй ажлын байруудын жагсаалтыг гаргасныг хүргэж байна.

1. ХУВИЙН ТУСЛАХ

Ихэнх ажлын байрууд ажлын тогтсон цагтай байдаг. Гэхдээ хувийн туслахууд 24/7 бэлэн байх ёстой гэхэд хилсдэхгүй болов уу. Энэ төрлийн ажилтнуудад гүйцэтгэх ажил маш олон байдаг тул зохион байгуулалт, цаг төлөвлөлтийн өндөр ур чадвар шаардагддаг билээ.

2. ГЭРЛЭЛТ БА ГЭР

Өдрийн цайны цаг болон оройн цагаар рестораны гал тогоо хэрхэн ажиллагчийг бид уран сайхны кино болон цөөнгүй нэвтрүүлгээс үзсэн билээ. Тэд үйлчлүүлэгчдийн захиалгыг цаг тухайд нь, чанартайгаар бэлдэж өгөх ёстой. Багийнх нь гишүүн багахан алдаа гаргахад л өмнөөс нь хариуцлага хүлээх шаардлагатай болдог. Чадварлаг хамт олноо алдалгүйгээр барьж, захиалга бүрийг чанартай гаргахын тулд тэд юуг ч хийхэд бэлэн байдаг гэж хэлж болно. Үүнээс гадна тэд энэ бүх хугацаанд халуун зуухны

Тэд тэнгэрт нисэж буй онгоцнуудын хөдөлгөөнийг хянаж, нисгэгчид чиглүүлэг өгдөг. Мөн нисэх онгоцны буудал болон нисэх зурваст газар дээрх хөдөлгөөнийг ч хянана. Тэд мөнхийн сонор сэрэмжтэй байхаас гадна ямарваа нэг асуудал гарах үед нисгэгчид зөвлөгөө өгдөг.

11. СПОРТЫН ШҮҮГЧ

Спортын тэмцээн уралдааныг зурагтаар үзэхэд л догдолдог. Гэтэл талбайн хажууд зогсоод торгууль өгч, ялагчдыг тодруулна гэдэг хэчнээн хэцүү гэж бодно? Тоглогч, дасгалжуулагч, бүр үзэгчдийн байнгын хэл амтайгаас гадна амь насанд нь заналхийлэх тохиолдол ч байдаг байна.


12. БАГШ

Бид жилд нэг удаа зохион байгуулагддаг “Сурагчдын нэг өдөр” өдөрлөгөөр л багшилна гэдэг хэчнээн хэцүүг мэдэрдэг. Сурагчдаа мэдлэгийг сургалтын төлөвлөгөөний дагуу олгохоос гадна “хэцүү” сурагчидтай харьцана гэдэг...

Тэд энэ ажлыг жилийн ганцхан өдөр биш, бүхий л өдөр хийдэг гэхээр хайрлахгүй байхын аргагүй билээ.

13. ОПЕРАТОР

Ширээний ард суугаад л хүмүүстэй өдөржин утсаар ярина гэхээр дэлхийн хамгийн амархан ажил шиг санагдаж магадгүй юм. Царайг нь ч хараагүй хүндээ утасны цаанаас бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулахаас гадна бухимдсан хэрэглэгчидтэй ярьж, асуудлыг нь шийдвэрлэхэд туслах



БҮЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ

Хосын харилцаанд үүссэн асуудал, дутагдсан мэдрэмжийг нөхөх, бие биеийнхээ ялгаатай талыг нь хүлээн зөвшөөрүүлэх зэрэг нь амаргүй гэдэг нь тодорхой. Үйлчлүүлэгчдийнх нь харилцаа хурцадмал байдалд орсон бол асуудлыг намжаах нь ч мөн гэр бүлийн сэтгэл зүйчдийн хийх ажил. Гэхдээ мэдээж хамгийн сайхан нь тэднийг эвлэрч, аз жаргалтайгаар хөтлөхөөн гарахыг харах явдал билээ.

3. САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ

Санхүүгийн олон тоо баримт, өгөгдлийг судалж, бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын тухай зөвлөгөө, чиглүүлэг өгөх ажлыг санхүүгийн шинжээчид хийдэг. Хэдийгээр тэд үргэлж стресстэй ажиллахгүй ч зах зээлийн нөхцөл байдал муугаар эргэх үед олон хэцүү үйлчлүүлэгчидтэй нүүр тулах болдог.

4. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ АЖИЛТАН

Гомдол барагдуулах ажилтнууд үргэлж л ямар нэгэн асуудал тулгарсан үйлчлүүлэгчтэй харьцдаг. Тэд үүсээд буй нөхцөл байдлыг намжааж, хэрэглэгчийн гомдлыг мэргэжлийн түвшинд, цаг тухайд нь шийдвэрлэх ёстой байдаг. Аливаа байгууллагын хувьд хэрэглэгч нэн тэргүүнд байдаг тул гомдол барагдуулах ажилтан бол яах аргагүй чухал ажлын байр билээ.

5. БАРИЛГЫН АЖИЛТАН

Биеийн хүчний ажил хүнийг бие махбод болон сэтгэлзүйн аль алианаар нь ядраадаг. Тэд цаг агаарын эрс тэс, эрсдэлтэй нөхцөл байдалд ажиллахаас гадна үргэлж л дээд албан тушаалын хэн нэгэн нь тэдэнд зааж зааварлаж байдаг.

6. АХЛАХ ТОГООЧ

хажууд байдаг гээд бод доо.

7. ГАЛТ ТЭРЭГНИЙ ЖОЛООЧ

Галт тэрэгний жолооч болохын тулд нүдний хараа дээд зэргийн сайн байх ёстой. Ингэж байж л тэд зорчигчдоо зорьсон газарт нь аюулгүй, хугацаанд нь хүргэж өгч чадна. Сонсоход



амар, сонирхолтой юм шиг сонсогдож байж магадгүй ч маш их хариуцлага хүлээдэг албан тушаал юм шүү.

8. НИСЭХ ОНГОЦНЫ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИНЖЕНЕР

Тэд нисэх онгоцны хөдөлгүүр суурилуулахаас эхлээд цахилгаан болон системтэй холбоотой гэмтлийг засаж гүйцэтгэдэг. Мэдээж агаарт нисэж буй зорчигчдыг хүрэх газарт нь аюулгүй хүрэхэд тээвэрлэж буй онгоц нь эвдрэл гэмтэлгүй, “төгс” байх ёстой. Хүний амь настай холбоотой ажил байх нь шүү дээ.

9. АЧААНЫ МАШИНЫ ЖОЛООЧ

Өдөржин жолоо бариад л урагшаагаа яваад л байхад болох юм шиг санагдаж байж болох ч ачааны том том машиныг хот дотор унах нь үнэхээр амаргүй байдаг аж.

10. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДАГЧ

шаардлагатай тулгардаг. Мэдээж чи байгууллагынхаа өмнөөс тухайн хэрэглэгчтэй ярьж байгаа учир өөдөөс нь бухимдсан өнгө аясаар ярьж ч болохгүй.

Харилцааны чадвар сайтай нэг нь энэ албан тушаалаас карьераа амархан дээшлүүлж чаддаг бол сэтгэлзүйдээ хүнд шарх авах нэгэн ч бий.

14. СЭТГЭЛ ЗАСАЛЧ

Сэтгэлзүйн шинжлэх ухаан бол судалж барамгүй өргөн цар хүрээтэй салбар билээ. Иймд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл санааны болон сэтгэцийн эмгэгийг эмчлэхийн тулд олон тооны ном товхимол, судалгаа шинжилгээг уншиж судлахаас эхлээд маш их ачааллыг үүрэх шаардлагатай болдог. Кинон дээр намуухан орчинд суугаад, үйлчлүүлэгчтэйгээ ярилцаад, их л амар тайван ажил шиг харагддаг боловч угтаа бол тийм биш аж.